



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/АЧ

Булган сум

### Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дах заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг сумдад тараах хуваарийг хавсралтаар баталж, 1 боодол өвсний үнийг 6,500 (зургаан мянга таван зуу) төгрөг, 1 тонн тэжээлийн үнийг 900,000 (есөн зуун мянга) төгрөгөөр худалдан борлуулахыг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал (Б.Одхүү)-д зөвшөөрсүгэй.

2.Худалдан борлуулсан өвсний 6,000 (зургаан мянга) төгрөг, тэжээлийн 830,000 (найман зуун гучин мянга) төгрөгийг Мал хамгаалах сангийн 100040051410 дансанд, өвсний 500 (таван зуун) төгрөг, тэжээлийн 70,000 (далан мянга) төгрөгийг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн 5286274015 дансанд тус тус төвлөрүүлэхийг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал (Б.Одхүү)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 16-ны өдрийн А.А.А. дугаар  
захирамжийн хавсралт



АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН  
ӨВС, ТЭЖЭЭЛИЙГ СУМДАД ТАРААХ ХУВААРЬ

2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр					
Д/д	Сумын нэр	Өвс		Тэжээл	
		Тоо хэмжээ (боодол)	Үнэ (6,500 төг)	Тоо хэмжээ (тн)	Үнэ (900,000 төг)
1	2	3	4	5	6
1	Баяннуур	2,000	13,000,000	4.8	4,320,000
2	Дашинчилэн	2,000	13,000,000	5.4	4,320,000
3	Гурванбулаг	1,500	9,750,000	4.8	4,320,000
4	Рашаант	1,500	9,750,000	4.8	4,320,000
5	Сайхан	1,500	9,750,000	5.4	4,320,000
	<b>Дүн</b>	<b>8,500</b>	<b>55,250,000</b>	<b>25.2</b>	<b>22,680,000</b>
2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр					
1	Баяннуур	5,00	3,250,000	4.8	4,320,000
2	Дашинчилэн	1,000	6,500,000	4.8	4,320,000
3	Гурванбулаг	1,000	6,500,000	4.8	4,320,000
4	Рашаант	1,000	6,500,000	4.8	4,320,000
5	Могод	1,000	6,500,000	4.8	4,320,000
6	Сайхан	1,000	6,500,000	4.8	4,320,000
	<b>Дүн</b>	<b>5,500</b>	<b>37,750,000</b>	<b>28.8</b>	<b>25,920,000</b>